

1. ӨМГӨӨЛӨГЧ АСУУЛТУУД БЭНГОШИ

- 1.1. 10-р сард Сэнмон-д сурахаар төлбөрөө төлсөн боловч виз нь гараагүй. Гэвч сургуулиас төлбөрийг нь буцааж өгөхгүй байна. 50 ман орчим. Яах вэ?

ХАРИУЛТ:

Япон улсад сургуульд орох үед ЭЛСЭЛТИЙН ХУРААМЖ - НЮУГАКУКИН болон СУРГАЛТЫН ТӨЛБӨР-ГАКУХИ хэмээх 2 янзын төлбөрийг авдаг.

ЭЛСЭЛТИЙН ХУРААМЖ нь тухайн сургууль оюутанг элсүүлэн авахыг хүлээн зөвшөөрч элсүүлэх журмынхаа дагуу ажил үүргээ гүйцэтгэхэд зориулсан төлбөр юм. Сургуульд элсэн суралцахын тулд Япон улсад оршин суух зөвшөөрлийг авах ёстой ба сургуулийн зүгээс бүрдүүлэн өгсөн материалыг Иммигрэшн шалган үзэж шийдвэрлэдэг.

Дээрх тохиолдолд Иммигрэшнээс оршин суух зөвшөөрөл олгоогүй учир төлөгдсөн нюүгакүхи-г сургууль иргэнд буцаан төлөх үүрэг хүлээхгүй. Үйл ажиллагааныхаа хөлс болгон авах нь зүй ёсны хэрэг хэмээн үзэх нь олон байдаг. Харин ЭЛСЭЛТИЙН ХУРААМЖ дотор СУРГАЛТЫН ТӨЛБӨР –ийн тодорхой хувийг хамт төлсөн бол зөвхөн СУРГАЛТЫН ТӨЛБӨР-ийг буцаан авахаар нэхэмжилж болно.

Сургалтын төлбөрөө төлөх үедээ тухайн бүхэл дүнгийнхээ задаргааг буюу хэдийг нь элсэлтийн хураамж, хэдийг нь сургалтын төлбөртөө төлж байгаагаа нягталж байх шаардлагатай бөгөөд Тухайн элсэлтийн хичээл эхлэхээс өмнө 4сард хичээл эхлэх бол 3сардаа багтаж нэхэмжлэх нь зүйтэй.

- 1.2. Дансны дугаар андуураад 100,000 иэн шилжүүлсэн. Банкинд хандсан боловч цаад хүн нь үрчихсэн гээд төлж чадахгүй гэнэ. Энэ тохиолдолд яах ёстой вэ?

ХАРИУЛТ:

Бусдын эзэмшлийн зүйлийг санаатайгаар үрсэн хэрэг хэмээн цагдаа болон иргэний шүүхэд мэдэгдэж шалгуулж хэрэг үүсгэж болох боловч бага хэмжээний мөнгөн дүнд цагдаа нар хөдөлж өгдөггүй бөгөөд өмгөөлөгчөөр хөөцөлдүүлэхэд багадаа 200,000-300,000 иен шаардагддаг тул олж авах мөнгөнөөсөө зардал нь даваад утгаа алддаг. Япон улсад өмгөөлөгчийн төлбөрийг хэрэгтнээр төлүүлэх ёстой гэх хуулийн заалт байхгүй .

Доод тал нь 500,000-аас дээш иен биш бол буцаан олж авахад хүндрэлтэй хэмээн үзэж дор бүрнээ болгоомжтой байх нь хамгийн зөв зам болдог.

- 1.3. Хүчингийн хэрэг хийхийг завдсан гээд ял авсан иргэн давж заалдаж ялах магадлал хэдэн хувь байх вэ? (2 гадаад иргэн)

ХАРИУЛТ:

Япон улсад гэмт хэрэг үйлдсэн болон үйлдэхийг завдсаныг 90% орчмын үндэслэлтэй хэмээн тодорхойлсон бол ял эдлүүлдэг. Хүчингийн хэрэг үнэхээр хийгээгүй үед ял эдлүүлнэ гэдэг барагтаа байж боломгүй ч үнэхээр өөрийгөө үйлдээгүй гэж байгаа бол хичээгээд давж заалдаж болно.

Нэгэнт оноогдсон ялыг хүчингүй болгох нь 0,001% магадлал байдаг. Уг хэргийг нарийн сайн мэдэхгүй учир Ялах магадлалын хувьд уг тодорхой хариулт өгөх тодорхойлох боломжгүй.

2. ЗАСАГ ЗАХИРГААНЫ АЛБАН БИЧИГЧ ГЁОСЭЙШЁШИ АСУУЛТУУД

- 2.1. Би 3 жилээр дадлагажигчаар ирээд одоо хугацаа нь дуусч байгаа юм.Тэгээд буцаж ирмээр байгаа. Гол нь буцаад энэ компанидаа ирсэн нь дээр үү? Эсвэл шинэ виз болох тохотэйгиногоор ирсэн нь дээр болов уу?

ХАРИУЛТ:

Дадлагажигч виз нь хугацаагаа дуусгаад заавал эх орондоо харих нөхцөлтэй ба гэрээ дууссаны дараагаар заавал нутаг буцах ёстой. Харин эргэн ирэхдээ дадлагажигчаар ирэхээр бол өмнө нь хийж байсан чиглэлийнхээ хүрээнд /барилга бол барилга, асрагч бол асрагч/ хамгийн дээд тал нь 2 жилийн хугацаанд ирэх боломжтой байдаг.

одоо Дадлагажигчаар байх хугацаандаа тохотэйгиногийн шалгалтыг нь өгөөд эрхээ авчихвал заавал нутаг буцах шаардлагагүйгээр Японд визний төрлөө өөрчлөөд шууд үргэлжлүүлэн ажиллаж амьдрах боломжтой.

Шинэ тохотэйгино визний тухайд, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн байх шаардлагатай.

- 2.2. Нөхөр дээрээ аялалын 3 сараар очих гэж байгаа. Очсон хойноо гэр бүлийн Виз мэдүүлэх юм. Ямар бичиг баримт мэдүүлэх, Монголоос ямар ямар бичиг баримт бүрдүүлж очих шаардлагатай эсэх? Өмгөөлөгч авбал гарах болов уу? Үнэ хөлс нь хэд байдаг бол? Гарахгүй байлаа гэхэд өмгөөлөгчийн мөнгөө заавал төлөх үү ?

ХАРИУЛТ:

Монголоос ирэхдээ гэр бүлийн баталгаа, тодорхойлолт орчуулгатай, цээж зураг, хамт авхуулсан зураг байхад болно. Нөхрийн чинь зүгээс олон материал шаардлагатай.

Өмгөөлөгч аваад гарна гэж 100% хэлж чадахгүй, Хэрэв баталгаатай гаргаж өгнө гэсэн өмгөөлөгч байгаа бол тэр өмгөөлөгч 100% худал хэлсэн гэж ойлгож болно. Төлбөрийг хэдэн хувь төлснөөс шалтгаалж виз гараагүй тохиолдолд үйлчилгээний хөлсийг суутган төлбөр буцаан олгогдох эсэх нь шалтгаална. Тухайн үйлчилгээний газартай хийсэн гэрээгээр зохицуулна.

Аяллын визээр ирээд бусад визний төрөл рүү шилжүүлэх боломжгүй байдаг. Харин аяллаар ирсэн хугацаандаа материалаа бэлтгэж өгөөд энд байх хугацаанд хариу ирэхгүй бол заавал нутаг буцаж хариугаа аваад буцаж ирнэ.

- 2.3. Визний хугацаа хэрхэн сунгах вэ?

ХАРИУЛТ:

Ямар төрлийн виза сунгуулахаас шалтгаалан тус бүр өөр өөр баримт бичиг шаардлагатай. Визний төрөл болгоны хувьд бүрдүүлэх бичиг баримтуудыг Веб сайтаас тодруулах боломжтой байгаа. [ЭНЭ](#) линкээр орж дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

- 2.4. Дадлагажигчаар ажиллаж байх хугацаандаа гэр бүлийнхээ хүмүүсийг урих боломжтой юу? 4 сараас хууль өөрчлөгдөөд урьж болдог болсон гэж сонссон энэ үнэн үү?

ХАРИУЛТ: Боломжгүй. Тийм хууль гараагүй.

- 2.5. Иргэншил солиход ямар бичиг баримт шаардлагатай вэ?

ХАРИУЛТ:

Эцэг эхийн зөвшөөрөл, 3-н үеийн намтар, төрсөн үеээс одоог хүртэлх бүх намтар түүх, иргэншил солих болсон шалтгаан, гадаад дотоодод явж байсан түүх зэрэг бичиг баримтууд шаардлагатай.

Хамгийн гол нь Японы хилээр орж ирсэнээс хойшхи бүхий л мэдээллүүдээ үнэн зөв мэдүүлэх шаардлагатай. Иргэншлийн зөвшөөрлийг Имэгрэйшнээс гаргадаггүй Гадаад иргэдийн бүх төрлийн мэдээлэл шүүж хянаж Япон улсын Хууль зүйн Яамнаас зөвшөөрөл олгодог.

2.6. Хууль бус иргэдэд визтэй болгох арга байдаг уу?

ХАРИУЛТ:

Хууль бусаар оршин суусан иргэдэд зайлшгүй тусгай шалтгаанаар виз олгох тохиолдол байдаг. Байнгын оршин суугч, Япон иргэний гэр бүл болсон тохиолдолд онцгой виз хүсэж мэдүүлэг хийж болно.

Өмнө нь Тэйжүүша буюу тусгай оршин суугчтай гэр бүл болсон визгүй иргэнд нөхцөл байдлыг нь харгалзан үзэж виз олгож байсан бол сүүлийн үед чангарсан. Тусгай оршин суугч ч визээ сунгадаг тул ийнхүү авч үзэхээ больсон.

2.7. Хойд эцэг нь япон одоо удахгүй 20 хүрэх хүнд япон иргэн болход ямар бичиг баримт шаарддаг вэ?

ХАРИУЛТ:

Тухайн иргэншлээ солиулах иргэн оюутан уу, ажилтан уу? гэдгээс шалтгаалан бэлтгэх материал өөрчлөгдөөд явна. 5-р асуултанд хариулсны адилаар намтар түүх, гэр бүлийн танилцуулга, түүх, анх Японд ирснээс хойш бүх түүхийг харуулсан бичиг баримт шаардагдана.

2.8. Аялалын визтэй хүн визээ өөрчилж болох уу?

ХАРИУЛТ:

Шууд өөрчилөх боломжгүй, Аялалын визээр байх хугацаандаа өөр төрлийн виз мэдүүлж болно.

Монголоос визээ мэдүүлчихээд аяллын визээр ирээд байж байх хугацаанд визны зөвшөөрөл нь гарчихвал заавал нутаг буцалгүйгээр шинээр олгогдсон визнийхээ хүрээнд Япондоо үлдэж болно.

3. ТАТВАРЫН АСУУЛТУУД

3.1. Японд 1 жил ажиллаад татварын буцаалт олгодог эсэх талаар мэдээлэл өгнө үү?

ХАРИУЛТ:

年末調整 НЭНМАЦҮЧОСЭЙ гэдэг нь /жилийн эцсийн татварын тайлан/ хөдөлмөр эрхлэгчийн тухайн жилийн 1/1-12/31хүртэл 1 жилд төлөгдсөн цалингаас суутгагдсан ШОТОКҮЗЭЙ /орлогын албан татвар/ тооцох баримт бичгийг хэлдэг.

Япон улсад үндсэн болон цагийн ажилтны системээр хөдөлмөр эрхэлж байгаа бүх иргэд компани дээрээ 11 сарын эхнээс 12 сарын хооронд Нэнмацүчосэй зохицуулалт хэмээн баримт бичиг бөглөдөг. Үүнийг учрыг сайтар ойлгоогүй хэлснээр нь бөглөчихдөг тал байдаг.

ШОТОКҮЗЭЙ гэдэг нь НЭГ ЖИЛИЙН ХУГАЦААНД ОЛСОН ОРЛОГООС ТООЦОХ ТАТВАРЫГ хэлэх ба ажилтан нь сар бүрийн цалинг авах үеэр урьдчилан татвар нь суутгагдсан байдаг. Урьдчилан суутгагдсаныг мэдэгдэх хуудас нь 源泉徴収 ГЭНСЭНЧОШЮХЁ юм.

Шотокүзэй нь тухайн жил эхлэхээс өмнө урьдчилан суутгагддаг учраас хэрэв тухайн жил олсон орлого урьдчилж тооцогдсоноос бага /Ажил хийгээгүй завсардсан / байвал тухайн муж дүүргийн татварын хэлтэст он гарсны дараах 2-3 дугаар сард өөрийн биеэр очиж мэдэгдэл хийдэг. Үүнийг 確定申告 КАКҮТЭЙШИНКОКҮ гэдэг. Үүгээр урьдчилж илүү төлсөн татварын мөнгөө буцаан авах боломжтой болдог.

Япон улсад ажилласан нэг бүтэн жилийн нийт орлогыг тухайн жилийн эцэсээр тооцож татвар оногдуулаад, дараа жилийн орлогыг түүгээр багцаалж урьдчилан татвар суутгаж авдаг. Түүнийг нэнмацүчосэйгоор зохицуулалт хийж урьдчилан төлөгдсөн татварын илүү дутууг тооцож өгдөг гэсэн үг юм.

- 3.2. **Кайшы болон кайшыны захирлын төлөх татваруудыг нэрлэж өгнө үү. кайшынаасаа цалин авсан гэж түүнээсээ орлогын татвар төлдөг, хэдийг яаж бодож төлдөг вэ? сэцүзэ хийх ямар хувилбар байдаг вэ?**

ХАРИУЛТ:

Компанийн захирал ч ажилтны адил цалин авах учир шотокүзэй буюу орлогын албан татвар төлнө. Орлогын хэмжээнээс шалтгаалан компанийн орлого болон компанийн захирлын цалингаас 10%-35% хүртэл татвар суутгагддаг. Захирлын цалинг тогтоохдоо компанийн орлого зарлагатайгаа авцалдуулахгүй бол татвар болон санхүүгийн тайлангийн үеэр үнэлгээ мууддаг. Захирлын цалингийн хэмжээг дагаж компанийн татвар нэмэгдэх тал ч гардаг учир татвараа хэмнэхийг хүсвэл захирлын цалинд зохицуулалт хийх нь зүйтэй байдаг.

4. ДААТГАЛ АСУУЛТУУД

- 4.1. **Япон улсад олон жил амьдарч байгаа хэрвээ Монголруу нүүж амьдрах бол Японы тэтгэвэр авч болох болов уу? Буцах үедээ төлсөн татвараасаа хэдэн хувийг буцаан авч болдог гэж сонссон. Буцаалт хийхгүй тэтгэвэр авч болдог болов уу?**
- 4.2. **ХАА-н чиглэлээр дадлагажигчаар ажилладаг. 3 жилээ дуусгаад Монголд буцсан хойноо даатгалын мөнгө олгогдохгүй гэсэн энэ үнэн үү?**
- 4.3. **Тэтгэвэрийн даатгал, тэтгэмжийн талаар мэдээлэл өгнө үү?**
- 4.4. **Энд ажилдаг компанид нийгмийн даатгал (тэтгэвэр) төлж байгаад монгол бүүр буцах бол монголдоо очоод энд ажиллаж байсан нэнкин нь ажилсан жилд нь орох уу?**
- 4.5. **Японд тэтгэвэр төлж байгаа гадаад хүн сүүлийн 10-н жил төлсөн байхад 65 насандаа тэтгэвэр авна гээд байгаа гэвч 7-8-н жил төлчөөд авч чадахгүй нутаг буцах бол өдийг хүртэл төлсөн мөнгө буцааж олгох уу**

ХАРИУЛТ:

Энэ хүртэлх асуултуудыг базаж хариулахад:

Японд Сэдайканфүёо хэмээх нэр бүхий “Тэтгэврийн тогтолцоо” байдаг.

Энэ нь өмнөх үеийн ахмадуудаа 65 нас хүрэхэд нь өөрсдийн төлж буй даатгалын мөнгөний хуримтлалаас тэтгэвэр олгож явна. Харин татвар төлж буй бид бүхэн хөгширсөн хойноо дараагийн үеэсээ тэтгэвэр авна гэж ойлгож болно.

Япон улсад 10 жил тасралтгүй тэтгэврийн даатгал төлсөн гадаад иргэн 65 нас хүрэхдээ Японд амьдарч байвал тэтгэвэр авах боломжтой.

Гадаад иргэдийн хувьд 65 нас хүрэх үедээ Японд оршин сууж байх үгүйгээ мэдэхгүй атал энэхүү тэтгэврийн даатгалыг яагаад заавал төлөх ёстой гэж ?? гэсэн асуулт урган гардаг.

Энэ нь яалт ч гүй хуулинд заасан байдаг учир төлөх ёстой.

Харин 65 нас хүрэхдээ эх нутагтаа суунгаа Япон улсаас тэтгэврээ шилжүүлэн авах боломжтой азийн 4 орон байдаг ба хятад солонгос, энэтхэг, филиппин ордог. Япон Монгол 2 орны хооронд энэ тогтолцоог зохицуулсан гэрээ одоогоор хийгдээгүй байна.

Тиймээс Монголтой адил Япон улстай энэхүү гэрээг хийгээгүй орны иргэдийг хохироохгүйн үүднээс “Даттай ичижикин” буюу зөвхөн ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН төлсөн төлбөрөөс тодорхой хувийг буцаалт хийх нэг удаагийн тогтолцоог бий болгожээ.

Энэхүү нэг удаагийн буцаан олголтонд тогтоосон шаардлага байдаг.

- Япон улсад 6 сараас дээш хугацаанд тэтгэврийн даатгал төлсөн иргэн бүр мөсөн нутаг буцсан хойноо мэдүүлэг хийж нэг удаагийн буцаан олголтыг авна.
- Нэг удаагийн буцаан олголт нь төлж байсан нийт даатгалын мөнгө 100% биш зөвхөн нэг хэсэг нь буюу 10%-20% нь л олгогддог.

- Тэтгэврийн даатгалын төлж байсан хугацаанд хязгаар тогтоох ба 6 сараас 3 жил гэсэн хугацааг л авч үзнэ.

Тодруулбал, Японд 3-аас дээш жил тэтгэврийн даатгал төлсөн байсан ч буцаан олголтын дүнг хамгийн дээд тал нь 3 жилээр тооцож ойролцоогоор 275,000 иен төлөгдөж байна. Өөрөөр хэлбэл, 10 жил тасралтгүй төлсөн ч буцаан олголтоор авах мөнгө нь 275,000 иен байна гэсэн үг.

Иргэд нэг л зүйлийг сайтар ойлгох хэрэгтэй. Эх орондоо буцсаныхаа дараагаар төлсөн даатгалын буцаан олголт гэдэг ойлголт нь зөвхөн ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ буюу НЭНКИН –д хамааралтай. Нийгмийн даатгалын буцаан олголт гэж байдаггүй. Монгол, Япон 2 улсын хооронд нийгмийн даатгалын талаар гэрээ хийгдээгүй учир энэ тухай зохицуулалт одоогоор байхгүй. Энд төлж буй нийгмийн даатгалын төлбөрийг ч жилийг ч Монголд нөхөн оруулах боломжгүй.

Жич: Дээрх асуудлаар ЭСЯ-с тодруулга авсан бөгөөд доорх хариултыг өглөө.

“Манай орон ирэх оноос Нийгмийн даатгалын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулахаар шахаж ажиллахаар төлөвлөж байна. Өдийг хүртэл хэлэлцээр байгуулсан орнуудын иргэдийн тоотой манай орны иргэдийн тоог харицуулашгүй бага байсан. Одоо ч бага байна. Одоогоор манай иргэд 12,574 байна. Хятад 764,000 Солонгос 449,000 Вьетнам 330,000 Филиппин 271,000 иргэн байна” гэлээ.

Нийгмийн даатгалын салбарын гэрээ хийхэд Япон улсад оршин сууж буй иргэдийн тооноос хамаардаг байх нь.

Мөн Тэтгэврийн буцаан олголтын дүнг албан ёсны сайтаас тодруулсан хүснэгтийг доор хавсаргав. Мэдээллийн эх сурвалжийг [ЭНД](#) дарж дэлгэрэнгүй үзнэ үү.

Даатгал төлөгдсөн хугацаа	Олгох дүн (円)
6-с 12сар дотор (11сар хүртэл)	49,230
12-с 18сар дотор (17сар хүртэл)	98,460
18-с 24сар дотор (23сар хүртэл)	147,690
24-с 30сар дотор (29сар хүртэл)	196,920
30-с 36сар дотор (35сар хүртэл)	246,150
36 сараас дээш	294,380

Жич: Хамгийн сүүлийн төлөлтийн сар нь 2018 оны санхүүгийн жилд хамаарсан тохиолдолд олгох дүнгийн тооцоолол юм.

4.6. Кайшя дээр нийгмийн даатгал төлдөггүй хүн хувиараа заавал төлөх ёстой юу? яаж төлдөг вэ?

ХАРИУЛТ:

Япон улсад бүх компани, албан байгууллагууд нийгмийн даатгал төлөх үүрэгтэйг хуулиар заасан байдаг. Компани 50% -ийг , ажилтан 50%-ийг төлөх үүрэгтэй.

Тухайн компани цалингаас нийгмийн даатгалыг огт суутгадаггүй бол black компани буюу хар дансанд орохуйц зөрчилтэй байна гэсэн үг.

Үүнийг компаниасаа асууж тодруулах, Татварын алба болон Хөдөлмөр хамгааллын яаманд мэдэгдэж болдог.

5. СУРГУУЛИЙН АСУУЛТУУД

5.1. Их сургууль болон коллежид хэрхэн элсэн орох тухай мэдээлэл өгнө үү?

ХАРИУЛТ:

Япон улсын их, дээд сургуульд элсэх 2 төрлийн зам байдаг.

1. Японд хэлний бэлтгэлд суралцаж байгаад дэвшин суралцах
2. Монголоос шууд элсэх

Японд хэлний бэлтгэлд суралцаж байгаад дэвшин суралцах

Япон хэлний сургуульд 6-аас дээш сар суралцсан байх

Япон хэлний N2- N1 зэргийн түвшинтэй байх

Японы их дээд сургуулийн улс нийтийн элсэлтийн шалгалт болох EJU –д тэнцсэн байх гэсэн шалгуурыг тавьдаг.

Гэвч сургуулиудаас шалтгаалж энэ шаардлага нь уян хатан байх ч бий. Ялангуяа улсын томоохон сургуулиуд бол дээрх 3 шаардлагыг чанд баримтлах бөгөөд дээр нь англи хэлний TOEFL, TOEIC зэрэг шалгалтын оноог ч харах тохиолдол бий.

Мэргэжлийн сургууль буюу сэнмонгаккагийн хувьд харьцангуй шалгуур зөөлөнд тооцогддог ба N3 аас дээш түвшинтэй оюутанг элсүүлж авах тохиолдол олон байдаг.

Монголоос шууд элсэх

Монголоос элсэх тохиолдолд мөн адил сургуулиудын тухайн тухайн шаардлагад нийцүүлэх боловч нийтлэг шалгуур нь Япон улсын их дээд сургуульд элсэх EJU шалгалтанд тэнцсэн байдал болон JLPT, TOEFL, TOEIC зэрэг шалгалтуудын оноог харгалзана.

JLPT , EJU шалгалтуудын хувьд жилд 2 удаа явагддаг бөгөөд улс орон бүрт шалгалтын комиссууд томилогдож зохион байгуулдаг. Монголд бол Япон-Монгол төв, Япон улсын олон улсын сан гэсэн 2 байгууллага явуулдаг учир аль нэгэнд нь очиж зөвлөгөө мэдээлэл авах боломжтой.

5.2. Одоо Япон улсад ур чадварын дадлагажигч визээр ажиллаж байгаа. Виз дууссаны дараа Японы их дээд сургуульд барилгын инженер мэргэжлээр суралцах хүсэлтэй байгаа тул энэ чиглэлээр зуучилдаг байгууллага болон визний зөвөлгөө авахыг хүсч байна.

ХАРИУЛТ:

Дадлагажигч ажилтан нь гэрээ дуусгаад заавал эх орондоо нэг удаад харьж доод тал нь 1 жилийн дараагаас дараагийн визийг мэдүүлэх нөхцөл бүрддэг.

Барилгын инженер болон бусад дурын мэргэжлийг сонгож болно.

Нутаг буцахгүйгээр сургууль оръё гэвэл тухайн сургууль элсүүлэхийг хүлээн зөвшөөрөх боловч визний асуудлыг иммигрешн шийдвэрлэдэг учир энд хариулах боломжгүй.

5.3. Япон хэлний сургуульд сурахад тэтгэмж авч болдог уу?

ХАРИУЛТ:

Тэтгэлэг бий. Гэхдээ Хэлний бэлтгэлийн хувьд Японд ирсний дараагаас тэтгэлэг, хөнгөлөлт авах боломж бүрдэх бөгөөд шууд Монголоос ирэхдээ хамрагдах тэтгэлэг гэж байхгүй. Учир нь дор хаяж 6 сарын хугацаанд тухайн оюутны хичээлийн ирц, дүнгийн үнэлгээ, JLPT, EJU зэрэг шалгалтын оноо зэргийг харгалзан үздэг.

6. ҮЛ ХӨДЛӨХ АСУУЛТУУД

- 6.1. Гадаадын иргэн байр худалдан авахад хэдий хэр хугацааны визтэй байх вэ? юун дээр анхаарах вэ?

ХАРИУЛТ:

Байнгын иргэншлийн визтэй байх шалгуурыг гол болгодог. Япон улсад оршин суух зөвшөөрөлгүй иргэний хувьд өөрийн хөрөнгийг гол үзүүлэлт болгон хардаг.

7. АЖИЛД ОРОХ АСУУЛТУУД

- 7.1. Япон дахь Монголын элчинд ажилд орох бол ямар шаардлагыг хангах ёстой бол?

ХАРИУЛТ:

Гадаад харилцааны яамнаас томилогдож ирдэг.

1. Төрийн албаны шалгалт
2. Дипломат албаны шалгалт

гэсэн 2 төрлийн шалгалтанд тэнцвэл нөөцөнд бүртгэгдэх ба ажлын байр гарахыг хүлээдэг.

- 7.2. Сувилагчаар дагнаад ажиллах хүсэлтэй байгаа ба энэ талаар ажилд зуучлуулах хүсэлтэй байна. Мэдээлэл өгч болох уу?

ХАРИУЛТ:

Асаргаа, Сувилагч нь тусдаа мэргэжилүүд. Яг сувилагч мэргэжилээрээ ажиллах хүсэлтэй бол тухайн мэргэжилээр ажиллах эрх бүхий мэргэжлийн шалгалтууд өгч тэнцсэн тохиолдолд Японд ажиллах боломжтой болно.

- 7.3. Хэлний бэрхшээлээс болоод мэргэжлийн дагуу ажиллаж чаддаггүй учир яаж ажил олох вэ?

ХАРИУЛТ:

Ажил хайвал байгаа. Орон нутгуудад ажиллах хүчний хомсдолтой байгаа учир Токио гэлгүйгээр бүс нутгуудад хайвал бүрэн боломжтой. Hello work зэрэг ажил хайхад дэмжлэг үзүүлдэг байгууллагуудад хандах нь чухал. Ер нь Япон хэл муу бол ажиллах хүн хүчний дутагдалд орсон бүс нутгуудад шалгуур бага учираас орох магадлал нэмэгдэнэ гэсэн үг.

8. АЯЛЛЫН ТАЛААР АСУУЛТУУД

- 8.1. Гэр бүл болон бусад хүмүүсээ японд аялуулахад аяллын кайшя нь визаг хөөцөлдөж өгөх үү?

ХАРИУЛТ:

Манай компани (Kaze no guokou) нь Монголд салбартай учираас манайхаар үйлчлүүлсэн тохиолдолд Монгол дахь салбартай холбогдоод визний материал бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой байгаа.